

## *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34-р тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 16/06 тоот тогтоолоор батлагдсан “МИК Холдинг Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журам”, тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн дагуу “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “МИК ОССК” ХХК-ийн байранд зохион байгуулж, хуралдуулахаар зарласугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
  1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
  3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай;
  4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
4. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 1-ийн дагуу баталж, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 2-ын дагуу баталж, 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 2-оос доошгүй өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевизээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, уг зарыг 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 3-ын дагуу баталж, энэхүү баримт бичгийг 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигч банкуудад албан шуудангаар, бусад хувьцаа эзэмшигчид тэдгээрт үйлчилж буй брокер дилерийн

компанид хүргүүлэх замаар танилцах бололцоог хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Мягмар овогтой Мөнхбаатарыг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга	Ж.Онон, ТУЗ-ийн ажлын албаны дарга
Гишүүн	Г.Саруул, ТУЗ-ийн нарын бичгийн дарга
Гишүүн	Ц.Алтантуяа, ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Гишүүн	Ч.Цэрэндулам, ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга	С.Амарсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газрын захирал
Гишүүн	Э.Маргад-Эрдэнэ, “МИК ОССК” ХХК-ийн Ипотекийн хөрөнгийн үнэлгээний хэлтсийн захирал
Гишүүн	Ж.Элбэгсайхан, “МИК ОССК” ХХК-ийн Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн захирал
Гишүүн	Б.Болортуяа, “МИК ОССК” ХХК-ийн Эрх зүйч, гэрээний хуульч
Гишүүн:	Т.Одгариг, “МИК ОССК” ХХК-ийн Хуульч
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын даргад үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг Хавсралт 4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт 5-ын дагуу тус тус баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгон тогтоосугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлыг төсвийг баталж санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Гантөгс)-д зөвшөөрсүгэй.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн ажлын алба (Ж.Онон)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.МӨНХБААТАР



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН МЭДЭГ ДЭЛ**

**Компанийн нэр:** “МИК Холдинг” ХК

**Хаяг:** Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар

**Хурал хуралдах огноо, цаг, газар:** 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт  
“МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны  
өргөн чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот)

**Хуралд хуралдах шийдвэр гаргасан огноо:** 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

**Олон нийтэд зарлах огноо:** 2016 оны 3 дугаар сарын 21-ны өдөр

**Бүртгэх өдөр:** 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

**Хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:** 2016 оны 3 дугаар  
сарын 25-ны өдөр.

**Хүргүүлсэн огноо:** 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөр


**Хурлын баримт, бичгийн хуудасны тоо \_\_\_\_\_ ширхэг, \_\_\_\_\_ хуудас**

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА ...../...../

2016 оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН ..... /...../

2016 оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ний өдөр



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

**Компанийн нэр:** “МИК Холдинг” ХК

**Хаяг:** Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар

**Хурал хуралдах огноо, цаг, газар:**

2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10:00 цагт “МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот)

**Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдөр:**

2016 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай;
4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах;

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах, газар, түүний ажиллах цаг:**

- Хувьцаа эзэмшигчид 2016 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандаж эсвэл компанийн байранд ирж хурал зохион байгуулах комиссын даргад мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцаж болно.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-13:00, 14:00-18:00 цагийн хооронд ажиллана.

**Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:**

Дарга Ж.Онон ТУЗ-ийн ажлын албаны дарга

Email: onon@mik.mn

Утас: 328267 ext 815

Гишүүн: Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: saruul@mik.mn

Утас: 328267 ext 825

Гишүүн: Ц.Алтантуяа ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: altantuya@mik.mn

Утас: 328267 ext 828

Гишүүн: Ч.Цэрэндулам ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: tserendulam@mik.mn

Утас: 328267 ext 838



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**


1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын 16/24 тоот тогтоол
4. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан
5. Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
6. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
7. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн хурлын 16/22 тоот тогтоол
8. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг оруулах тухай батлах тухай;
9. Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төсөл
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүд
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудаар гарах тогтоолыг төсөлд санал өгөх саналын хуудас

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2016 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
16/24 тоот тогтоолын Хавсралт №4



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ДЭГ**

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцагч
1	Хурлын ирцийг бүртгэх	10:00-10:15	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	10:15-10:20	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлын дэгийг танилцуулах	10:20-10:30	Хурлын дарга
4	Хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина.  1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай; 2. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах; 3. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийн батлах тухай; 4. Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах тухай;	10:30-11:00	Хурлын дарга
5	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	11:00-11:10	
6	Саналын хуудсаар ирүүлсэн саналыг авч, нэгтгэн, санал хураалтын дүнг хэлэлцэх асуудал бүрээр танилцуулна	11:10-11:40	Тооллогын комисс
7	Тооллогын комиссоос гаргасан санал хураалтыг дүнг үндэслэн ХЭХурлаас гарах шийдвэрийг хэлэлцэх асуудал бүрээр танилцуулна.	11:40-11:55	Хурлын дарга
8	Хурлыг хаах	11:55-12:00	Хурлын дарга



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИГТ ХУРДЫН САНАЛ ХУРААЛТЫН  
САНАЛЫН ХУУДАС**

1. Компанийн оноосон нэр: "МИК Холдинг" ХК
2. Хурал хуралдах газар, өдөр: 2016 оны 04-р сарын 28-ны Пүрэв гарагт.  
"МИК ОССК" ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг 1-р хороо 13-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар, 1007 тоот), 10:00 цагт
3. Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: .....
4. Регистрийн дугаар: .....
5. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн
6. Эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг: .....
7. Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: .....

№	Хэлэлцэх асуудал	Хэлэлцэх асуудлаар гарах ишийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдэлгэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах	Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон "Эрснт энд Янг Монголиа Аудит" ХХК-ийн гаргасан 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.				
2	Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай	МИК Холдинг" ХК-ийн дүрмийн 5.1 дэх хэсэгт "хувьцаатай байна" гэснийг "хувьцаатай байх бөгөөд түүнээс 20,709,320 (хорин сая долоон зуун есөн мянга гурван зуун хорь) ширхэг энгийн хувьцаа гаргасан байна" гэж өөрчилсүгэй.				
3	Компанийн ТУЗ-ийн зардлын 2016 оны төсвийн төслийг батлах	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг Хавсралт 1-д заасны дагуу баталсугай.				

**Саналын хуудсыг бөглөхөд анхаарах зүйлс**

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ “√” тэмдэглэгээг үзгээр тэмдэглэнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд, татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд “√” тэмдгийг зөвхөн үзгээр тавина. Үүнээс өөр тэмдэг болон үг үсэг бичсэн нь саналын хуудсыг хүчингүй тооцох үндэс болно.
2. Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч брокер дилерийн компанийн ажилтнууд бөглөн тэмдэг даран баталгаажуулж, хувьцаа эзэмшигчдэд өгнө.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн дотор хурлын материалтай танилцах бөгөөд хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг брокер дилерийн компанидаа санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хэрэв та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол саналын хуудсыг итгэмжлэлийн хамт ирүүлнэ үү.

Хувьцаа эзэмшигч иргэний нэр: .....	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр: .....
Гарын үсэг:.....	Албан тушаал:..... Гарын үсэг: .....
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг: .....	
Саналын хуудсыг хүлээн авсан Брокерын нэр, гарын үсэг: ...../...../	
Огноо, цаг: .....	
Саналын хуудсыг хүлээн авсан Тооллогын комиссын гишүүн: .....	
Огноо, цаг: .....	

**Саналын хуудсыг хүчингүйд тооцсон:**

1. Саналын хуудсыг хүчингүйд тооцсон Тооллогын комиссын дарга.....  
Комиссын гишүүд.....  
Комиссын гишүүд.....  
Комиссын гишүүд.....  
Комиссын гишүүд.....  
1116216038 : 5221978
2. Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:.....  
.....

❖ Хэрэв хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер дилерийн компаниудаар дамжуулан хурал зохион байгуулах комисст хүлээлгэн өгөх хугацаа **2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17:00 цагаар** тасалбар болгох бөгөөд үүнээс хойш хувьцаа эзэмшигч саналын хуудсыг бөглөн хурал зохион байгуулах комисст **2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 10 цагаас өмнө “МИК ОССК” ХХК-ийн байранд (Сүхбаатар дүүрэг 1-р хороо 13-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19, 10-р давхар)** хүлээлгэн өгч болно.